

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн 2 /хоёр/ хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн хугацааг сунган хавсралтаар баталгаажуулсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2014 оны А/409 дүгээр захирамжийн Бодит Амжилт ХХК, 2014 оны А/243 дугаар захирамжийн Номт Монгол ХХК-д холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрх нь сунгагдсан аж ахуйн нэгж байгууллагатай газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба /Ж.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ